



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020.12.07 № 19/5314
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 28 тоот албан бичгээр ирүүлсэн асуултын хариуг хүргүүлж байна.

Дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, тархалтыг таслан зогсооход чиглэн эрүүл мэндийн салбар бүхий л хүчин чадлаараа зүтгэж, ажиллаж байна.

Халдварын тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Цэргийн төв эмнэлэг, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийг коронавируст халдварын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр суллан бэлэн байдалд шилжүүлэн тусгаарлан ажиглалт, эмчилгээ, хяналтыг хийж байгаа билээ.

Манай Улсад КОВИД-19 халдвар 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар нийт 888 тохиолдол бүртгэгдсэнээс 383 тохиолдол гадаад улс орноос зөөвөрлөгдөж, 505 тохиолдол дотоодын халдвар бүртгэгдээд байна.

Коронавируст халдварын улмаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байгаа иргэдийн биеийн байдлын хувьд 420 хөнгөн, 67 хүндэвтэр, 7 хүнд, 1 нэн хүнд эмнэлзүйн шинж тэмдэгтэй байна.

Тус яамнаас коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, ОХУ, Япон улс болон олон улсын судалгаа шинжилгээ, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний аргачлалд үндэслэн үндэсний оношилгоо, эмчилгээний зааврыг байнга шинэчлэж батлан, хэрэгжилтийг хангах хүрээнд эмнэлгийн мэргэжилтнийг сургах, гарын авлага боловсруулан хэвлүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна.

1. Коронавируст халдвартай нэг иргэнд зарцуулж байгаа зардлын тоон мэдээллийг хавсралтаар танд хүргүүлж байна. Тус зардалд коронавируст халдварын оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслээс гадна эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлзүйн болон лабораторийн эмч, сувилагч, техникч, тандалт судалгааны ажилтан, эмзүйч болон дэмжих үйлчилгээнд ажиллаж байгаа тогооч, үйлчлэгч, жолооч нарын 25 гаруй чиглэлийн албан хаагчийн цалин (1 албан хаагчийн өдрийн дундаж цалин 9.5 мянган төгрөг) багтсан байдаг.


144207703

2. Эмчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ажиллах багийн бүрэлдэхүүн эмнэлзүйн хэлбэрээс хамрааран 1 багт оногдох өвчтөний тоо болон зарцуулагдах зардал харилцан адилгүй байна.

3. Коронавируст халдвар батлагдсан тохиолдлын эмчилгээнд хамрагдаж байгаа тоон мэдээлэлд халдвар авсан иргэний ойрын хавьтал болон тусгаарлан ажиглалтад байгаа иргэд хамаарахгүй болно.

Хүндэтгэсэн,

САЙД



Т.МӨНХСАЙХАН

**Коронавируст халдвартай нэг иргэнд зурцуулагдаж
байгаа эмчилгээний зардал**

д/д	Зардлын зүйл анги	Дундаж зардал	Дундаж ор хоног	Бүгд
1	Цалин, урамшуулал	244,303.5	28	6,840,496.7
2	Эм, эмнэлгийн хэрэгсэл	393,726.4		393,726.4
3	Хувийн хамгаалах хэрэгсэл	624,658.5		624,658.5
4	SARS-CoV-2 вирүсийг илрүүлэх нуклейн хүчилд суурилсан шинжилгээ (бх-ПГУ)	960,000.0		960,000.0
5	Цусны ерөнхий шинжилгээ	22,000.0		22,000.0
6	Цусны бүлэгнэлт	20,800.0		20,800.0
7	Шээсний ерөнхий шинжилгээ	12,400.0		12,400.0
8	Биохими	226,025.0		226,025.0
9	Дүрс оношилгоо	235,650.0		235,650.0
10	Бусад шинжилгээ*	38,719.0		38,719.0
11	Эмч, ажиллагсадын хоол	5,718.5	28	160,118.0
12	Өвчтөний хоол	7,360.5	28	206,094.0
13	Гэрэл цахилгааны зардал	1,297.0	28	36,314.8
14	Түлш, халаалтын зардал	1,350.3	28	37,807.8
15	Цэвэр бохир усны зардал	831.1	28	23,270.8
16	Хог хаягдлын зардал	316.5	28	8,862.7
17	Ариутгалын бодис	335.0	28	9,380.0
18	Тээврийн зардал	2,900.0	4	11,600.0
Нийт дүн				9,867,923.61

д/д	Зардлын зүйл анги	Дундаж зардал	Дундаж ор хоног	Бүгд
1	Цалин, урамшуулал	262,436.9	32.2	8,450,468.3
2	Эм, эмнэлгийн хэрэгсэл	496,966.5		496,966.5
3	Хувийн хамгаалах хэрэгсэл	865,350.0		865,350.0
4	SARS-CoV-2 вирүсийг илрүүлэх нуклейн хүчилд суурилсан шинжилгээ (бх-ПГУ)	1,425,000.0		1,425,000.0
5	Цусны ерөнхий шинжилгээ	30,100.0		30,100.0
6	Цусны бүлэгнэлт	27,840.0		27,840.0
7	Шээсний ерөнхий шинжилгээ	16,880.0		16,880.0
8	Биохими	172,990.0		172,990.0
9	Дүрс оношилгоо	299,500.0		299,500.0
10	Бусад шинжилгээ*	38,719.0		247,810.0
11	Эмч, ажиллагсадын хоол	5,718.5	32.2	184,135.7
12	Өвчтөний хоол	7,360.5	32.2	237,008.1
13	Гэрэл цахилгааны зардал	1,297.0	32.2	41,762.0
14	Түлш, халаалтын зардал	1,350.3	32.2	43,479.0
15	Цэвэр бохир усны зардал	831.1	32.2	26,761.4
16	Хог хаягдлын зардал	316.5	32.2	10,192.1
17	Ариутгалын бодис	335.0	32.2	10,787.0
18	Тээврийн зардал	2,900.0	4	11,600.0
Нийт дүн				12,598,630.10